



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/13

Улиастай

**Журам батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/264 дүгээр захирамжаар батлагдсан “Чадварлаг эмч” арга хэмжээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, орон байрны дэмжлэг үзүүлэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Ж.Должинсүрэн)-т даалгасугай.

ДАРГА



М.ҮРЖИНХАНД

D:/Tushaal/ -2024

• 202406200080

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 09 сарын 24 өдрийн  
1/13 тушаалын хавсралт

“Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн ажилтны нийгмийн  
баталгааг хангах, орон байрны дэмжлэг үзүүлэх журам

### Нэг. Үндэслэл:

1.1 Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.7 дахь хэсэгт заасан “Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

1.2 Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Чадварлаг эмч” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний зорилт 3-ын 3.3.1-д эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд газар олгох, орон сууцаар хангах, амьдрах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ гэж тус тус заасан.

### Хоёр. Баримтлах нийтлэг зарчим

2.1 Журмаар “Чадварлаг эмч” арга хэмжээний хүрээнд эмнэлгийн ажилтны нийгмийн баталгааг хангах орон сууцжуулахад дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

2.2 Монгол улсын үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, тогтоол шийдвэрт үндэслэгдэнэ.

2.3 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит бүх шатны эрүүл мэндийн байгууллага хамрагдана.

2.4 Материалыг нээлттэй авах бөгөөд шалгуурын дагуу бүрдүүлэн ажлын хэсэгт заасан хугацаанд ирүүлсэн байна.

2.5 Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж байгаа тохиолдолд дэмжлэг үзүүлэхэд нэг байгууллагаас оролцох албан хаагчийн тоо хязгааргүй байна.

2.6 Ил тод, нээлттэй байна.

2.7 Бодитой, үр дүнтэй байна.

2.8 Ашиг сонирхлын зөрчилгүй, шударга, хариуцлагатай байна.

### Гурав. Шалгуур үзүүлэлт

#### 2.1 Нийтлэг шалгуур:

2.1.1 Аймгийн эрүүл мэндийн салбарт 5-аас дээш жил тасралтгүй ажилласан байх, цаашид тогтвор суурьшилтай ажиллах;

2.1.2 Сүүлийн 1 жилийн хугацаанд ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын шийтгэл хүлээгээгүй;

2.1.3 Орон сууцны дэмжлэг авах эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь урьд нь орон нутгаас ямар нэгэн дэмжлэг аваагүй байх;

2.1.4 Эрүүл мэндийн ажилтны орон сууц, гэр нь гал, ус, байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд дэмжлэгийг өргөдлийн дараалал харгалзахгүй олгох;

2.1.5 Байгууллагын 70-аас дээш хувийн ирцтэй хамт олны хурлаас ажилтанд дэмжлэг олгох асуудлыг дэмжсэн байх;

## **2.2 Тусгай шалгуур:**

2.2.1 Эрхэлсэн ажилдаа шинэ санаа нэвтрүүлэн үр дүнг тооцож ажилласан байх;

2.2.3 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой эрүүл мэндийн чанарын үзүүлэлтэд сүүлийн 5 жилийн хугацаанд ахиц, дэвшил гаргасан байх;

2.2.4 Орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нэн шаардлагатай нарийн мэргэшлийн чиглэлээр суралцан ажиллаж байгаа;

2.2.5 Эрүүл мэндийн ажилтны өөрийн болон гэр бүлийн гишүүн (эхнэр, нөхөр)-ний нэр дээр ипотекийн зээлтэй, (20 сая төгрөг, түүнээс дээш мөнгөн дүнгийн үлдэгдэлтэй бол);

2.2.6 Тухайн эрүүл мэндийн ажилтны гэр бүлийн гишүүдийн аль нэг нь хөгжлийн бэрхшээлтэй бол;

## **Гурав. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах**

3.1. Эрүүл мэндийн газар нь жил бүрийн 03 дугаар сарын эхний 7 хоногт багтаан материалыг хүлээн авч, аймгийн Ажлын хэсгийн нарийн бичигт албан хэрэг хөтлөлтийн дагуу хүлээлгэн өгнө.

3.2. Материалыг хүлээн авч ажлын 3 өдөрт багтаан сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлд танилцуулна.

3.3 Шалгуур үзүүлэлтийг хангасан эмнэлгийн ажилтанд 20,000,000(хорин сая) төгрөгөөс дээш мөнгөн дэмжлэгийг үзүүлнэ.

3.4 Ажлын хэсгийн шалгаруулсан үр дүнгээр орон сууцны дэмжлэг үзүүлэх, олгох үйл ажиллагааг аймгийн Эрүүл мэндийн газар хариуцан зохион байгуулна.

## **Дөрөв. Хяналт, үнэлгээ**

4.1 Энэхүү журмын хэрэгжилтэд Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс хяналт үнэлгээ хийж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлд танилцуулна.